

“БАЯНТЭЭГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 сарын 11 өдөр

Арвайхээр сум

“Баянтээг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 03 дүгээр сарын 11-ны өдрийн 10 цаг 03 минутад Өвөрхангай аймаг, Арвайрээр сум “Нутгийн удирдлагын ордон”-ны 203 тоот хурлын танхимд эхлэв.

Хуралд Аймгийн засаг даргын орлогч О.Батжаргал, “Баянтээг” Хувьцаат компанийн гүйцэтгэх захирал О.Сумъяасүрэн, Ерөнхий инженер Л.Энх-Отгон, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичиг Б.Март, захиралын нарийн бичиг Л.Ган-Отгон нар эзэмшигчдийн ээлжит хуралд оролцов.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комисс дэгийн дагуу хурлын ирцийг танилцуулав.

“Баянтээг” ХК нь нийт 252,608 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаатай бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт саналын эрхтэй хувьцааны 0.00% буюу өөрийн биеэр, итгэмжлэлээр, саналын хуудсаар нэг ч хувьцаа эзэмшигч оролцоогүй.

О.Батжаргал: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц 0.00%-иар хурал хүчин төгөлдөр бус гэж үзэж “Баянтээг” ХК-ийн дүрмийн 6.4-т “Хувьцаа эзэмшигчдийн хурал нь саналын эрхтэй нийт хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч буюу тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцсоноор хүчин төгөлдөр болно” гэж заасны дагуу хурлын ирцийг хангаагүй гэж үзэв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хүрээгүй тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр оруулан зарлах уу.

О.Сумъяасүрэн: Хуулийн хугацааг нь харж байгаад өдөрөө ТУЗ-өөрөө шийдүүлэе.


О.Батжаргал: ТУЗ-ийн нарийн бичиг Б.Март одоо ТУЗ-ийн гишүүд рүүгээ яриад 2020 оны 03 дүгээр сарын 11-ний өдрийн 15.00 цагт хуралтай гэж зарла.

Б.Март: За

О.Сумъяасүрэн: Тэгвэл ТУЗ-ийн хурлаар дараагийн хурал хуралдах өдрийг товлох юм байна.

Хурлыг 2020 оны 03 дүгээр сарын 11-ний өдрийн 10 цаг 52 минутанд хаав.

Хурлын дарга:
Тамга



/О.Батжаргал/